

# ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ



2023 оны 09 сарын 15 өдөр

№ SR-2023-22

Улаанбаатар хот

ХасБанк ХК-ийн дүрэм батлах тухай

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.1 дэх заалт, Банкны тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2.1 дэх заалт, ХасБанк ("Банк")-ны хувьцаа эзэмшигчдийн 2023 оны 9 дүгээр сарын 15-ны өдрийн ээлжит бус хурлын шийдвэрийг тус тус үндэслэн:

## ТЭМДЭГЛЭХ нь:

1. Банкны Хувьцаа эзэмшигчдийн 2023 оны 3 дугаар сарын 27-ны өдрийн SR-2023-02 дугаартай тогтоолоор ХасБанкийг нээлттэй хувьцаат компани болгон өөрчлөн байгуулах тухай шийдвэр гаргаж, улмаар Хувьцаа эзэмшигчдийн 2023 оны 3 дугаар сарын 27-ны өдрийн SR-2023-03 дугаартай тогтоолоор эрх олгосны дагуу, Монголбанкны 2023 оны 4 дүгээр сарын 20-ны өдрийн А-1/374 дугаартай албан бичгээр өгсөн зөвшөөрөл, Санхүүгийн зохицуулах хорооны 2023 оны 5 дугаар сарын 12-ны өдрийн 179 дугаартай тогтоолд тус тус үндэслэн, Банк нь 52,700,000 (тавин хоёр сая долоон зуун мянга) ширхэг энгийн хувьцааг Монголын хөрөнгийн биржээр дамжуулан олон нийтэд санал болгосныг;
2. Банкнийг нээлттэй хувьцаат компани болгон өөрчлөн байгуулсны дагуу түүний дүрмийг Банкны нийтэд санал болгон гаргасан үнэт цаасны танилцуулгад хавсаргасан ёсоор олон нийтэд хувьцаа санал болгосны дагуу шинээр нэмэгдсэн хувьцаа эзэмшигчдийн оролцоотойгоор батлах шаардлагыг дурдан;
3. Энэхүү тогтоолыг баталсан өдөр Хувьцаа эзэмшигчид мөн SR-2023-21 дугаартай тогтоолыг батлан гаргаж, түүгээр хувь нийлүүлсэн хөрөнгийн өөрчлөлт, мөн түүнчлэн зарласан болон гаргасан энгийн хувьцааны тоог тогтоож батлах шийдвэр гаргасан болохыг, уг шийдвэрийн дагуу өөрчлөлтийг түүгээр эрх олгосны дагуу энэхүү тогтоолын 1 дүгээр хавсралтаар батлагдах Банкны дүрэмд тусгасан болохыг; мөн
4. Банкны дүрэм батлах эрх Банкны хувьцаа эзэмшигчдийн хуралд зөвхөн хадгалагддаг болохыг, Банкны хувьцаа эзэмшигчид ийнхүү Банкны дүрмийг хавсралт 1-д тусгасан ёсоор батлах хүсэлтэй байгаа тус тус тэмдэглэв.

## ТОГТООХ нь:

1. ХасБанк ХК-ийн Дүрмийг энэхүү тогтоолын Хавсралт 1-ийн дагуу шинэчлэн баталсугай.
2. Энэхүү тогтоолыг хэрэгжүүлэхтэй холбогдуулж хууль тогтоомжийн хүрээнд Банкны нэрийн өмнөөс бүхий л баримт бичигт төлөөлөн гарын үсэг зурах, Банкны дүрмийг бүртгүүлэх зэрэг шаардлагатай гэж үзсэн бүхий л арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Гүйцэтгэх захирал Г.Цэвэгжавд даалгаж холбогдох бүрэн эрхийг олгосугай.

3. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлаар шийдвэрлэсэн асуудал болон бусад холбогдох баримт бичгүүдийг Компанийн тухай хууль болон Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, холбогдох бусад журамд заасан хугацаанд зохих эрх бүхий байгууллагад хүргүүлэхийг Хууль хариуцсан захирал бөгөөд ТУЗ-ийн нарийн бичгийн дарга Н.Мөнхцэлмэгт үүрэг болгосугай.

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН  
ХУРЛЫН ДАРГА



САНЖАЙ ГҮПТА